



## БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/410

Улаанбаатар хот

Дүүргийн 9 дүгээр хорооны Ээж хайрханы  
1 дүгээр хэсгийн гэрэлтүүлгийн ажлын  
барьцаа хөрөнгө чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2016 онд Дүүргийн 9 дүгээр хорооны Ээж хайрханы 1 дүгээр хэсгийн гэрэлтүүлгийн ажлыг гүйцэтгэсэн “Эн Ар Жи Эм” ХХК-ийн ажлын барьцаа 1 514 041 /нэг сая таван зуун арван дөрвөн мянга дөчин нэгэн/ төгрөгийг барьцаа хөрөнгийн данснаас чөлөөлөхийг Засаг даргын Тамгын газар /Б.Амартүвшин/-т зөвшөөрсүгэй.

2. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эдийн засгийн хөгжлийн асуудал хариуцсан төслийн удирдагч-Засаг даргын орлогч Д.Уламбаярт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Т.БАЯСАХ